

Батлав: Хөөрөх Тавцан Сургуулийн Удирдах Зөвлөлийн Дарга А.Өсөхбаяр



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХӨӨРӨХ ТАВЦАН СУРГУУЛИЙН НЭГДҮГЭЭР АНГИД СУРАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. 2025-2026 оны хичээлийн жилд тус сургуулийн нэгдүгээр ангид элсэх элсэлтийг зохион байгуулах явцад үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2. Нэгдүгээр ангид сурагч элсүүлэхэд сургуулийн дүрэм, дотоод журам болон энэхүү журмыг баримтална.
- 1.3. Нэгдүгээр ангид элссэн хүүхэд бүр сургуулийн бэлтгэл хөтөлбөрт хамрагдана.
- 1.4. БШУ-ын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/200 тоот тушаалыг үндэслэн 1-р ангийн элсэлтийг “Зургаан настай хүүхдээс аливаа шалгалт, сорил авахгүй” бөгөөд эцэг эх, хүүхэд, сургуулийн “Хамтарсан уулзалт ярилцлага” хийж 1-р ангид сурагч элсүүлнэ.
- 1.5. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг элсэлтийн комиссын боловсруулсан үнэлгээний аргачлалын дагуу дүгнэнэ. Хамтарсан уулзалт ярилцлагад дараах байдлаар оролцоно. Үүнд:
 - а. Хамтарсан уулзалт ярилцлагад 6 настай хүүхэд өөрөө оролцоно.
 - б. 6 настай хүүхдээс гадна насанд хүрсэн хоёроос илүүгүй хүн оролцоно.
 - в. Насанд хүрсэн 2 хүн нь 6 настай хүүхдийн эцэг эх байх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай нөхцөлд эцэг эхийн аль нэг дангаар, эсхүл эцэг эхийг төлөөлсөн хүүхдийн асран хамгаалагч орж болно.
 - д. Бүртгүүлэх үед “Хамтарсан уулзалт ярилцлага”-д хүүхдийн хамт оролцох насанд хүрсэн 2 хүнээ сонгож бүртгүүлэх бөгөөд тухайн бүртгүүлсэн хүмүүс “Хамтарсан уулзалт” ярилцлагад орно.

ХОЁР. БҮРТГЭЛ

- 2.1. Бүртгэл цахимаар явагдана.
- 2.2. Бүртгэлийн хугацаа: 2025.03.10-ний өдрийн 17:00 цагаас эхлэн элсүүлэх хүүхдийн тоо бүрдэх хүртэл хугацаанд <https://www.huurhtavtsan.edu.mn/entry-information> цахим хаягаар бүртгүүлнэ.
- 2.3. Бүртгүүлэхэд анхаарах зүйлс:
 - а. Бүртгүүлэгч нь 2019.01.01-ээс 2019.12.31-ний хооронд төрсөн байх;
 - б. Бүртгүүлэгчийн овог нэрийг крилл үсгээр бичиж, регистрийн дугаарыг алдаагүй зөв оруулах;
 - в. Бүртгүүлэгчийн эцэг, эх асран хамгаалагч нь өөрийн и-мэйл хаяг, холбоо барих утасны дугаарыг заавал бичих;
 - г. Бүртгэлийн явцад үл буцаагдах нөхцөлтэй бүртгэлийн хураамж 20'000 / хорин мянга/ төгрөгийг төлөх тул дараах бэлтгэлийг хангаж бүртгүүлнэ үү.

- д. Бүртгүүлэгчтэй элсэлтийн комиссоос холбогдон Хамтарсан уулзалт ярилцлагын цагийг товлони.

ГУРАВ. “ХАМТАРСАН УУЛЗАЛТ” ЯРИЛЦЛАГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 3.1. “Хамтарсан уулзалт”-ын талаар чиглүүлэг өгөх уулзалтыг эхлэхээс 7 хоногийн өмнө цахим хэлбэрээр зохион байгуулна.
- 3.2. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг сургууль дараах байдлаар зохион байгуулна.
- а. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг элсэлтийн явцаас хамааран 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зохион байгуулна.
 - б. “Хамтарсан уулзалт” ярилцлагыг сургуулийн байранд явуулна.
 - в. “Хамтарсан уулзалт” ярилцлагын үргэлжлэх хугацаа нэг хүүхдэд 15-20 минут онооно.
 - г. Хамтарсан уулзалт” ярилцлагыг элсэлтийн комисс зохион байгуулах ба үнэлгээний аргачлалын дагуу дүгнэнэ.
- 3.3. Эцэг эхийн зүгээс ярилцлагад оролцоход анхаарах зүйлс:
- а. Ярилцлагын хуваарийн дагуу цагаа баримтлан ирэх;
 - б. Ярилцлагын үед гар утсаа унтраасан байх;
 - в. Чиглүүлэгч багш, ажилтны шаардлага, зөвлөгөөг хүндэтгэн мөрдөх;
 - г. “Хамтарсан уулзалт” ярилцлагын явцад зөвшөөрөлгүй бичлэг хийх, зураг авах, өөрсдийн ярилцлагын талаар үндэслэлгүй ташаа мэдээлэл цахим хуудсаар тараах, сургуулийн нэр хүндэд халдах, багш ажилтныг хэл амаар доромжлох, харилцаа, хандлагын зохисгүй байдал гаргахгүй байх;
- 3.3. “Хамтарсан уулзалт” ярилцлагаас хойш 10 хоногт багтан бүртгүүлэгчийн цахим шууданд элсэх эрх олгосон эсэх тухай мэдээллийг илгээнэ элсэгчийн имэйл хаягаар мэдээлнэ.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Цахим бүртгэл болон “Хамтарсан уулзалт” ярилцлагын үеэр үүсэх аливаа асуудал, санал гомдлыг сургууль бие даан шийдвэрлэнэ.
- 4.2. “Хамтарсан уулзалт” ярилцлагын үед ярилцсан агуулгыг задруулахгүй байхад сургуулийн зүгээс болон эцэг эхийн зүгээс анхаарна.
- 4.3. Сургуулийн зүгээс үүссэн техникийн аливаа саатлыг богино хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэнэ.
- 4.4. Цахим бүртгэлтэй холбоотой яаралтай асуух зүйлээ 9919 7935, 8011 8786 дугаарт холбогдож мэргэжлийн зөвлөгөөг 10:00-17:00 цагт авч болно.
- 4.5. “Хамтарсан уулзалт” ярилцлагатай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг 9919 7935 эсвэл 8011 8786 дугаараас 10:00-17:00 цагийн хооронд холбогдож лавлагаа авч болно.
- 4.6. “Хамтарсан уулзалт” ярилцлагын талаарх санал хүсэлтийг 06-р сарын 01-ны өдрийн 16:00 цаг хүртэл huurhtavtsan.edu.mn@gmail.com хүлээн авна.

Сургууль танилцуулах өдөрлөгийг 2025 оны 03-р сарын 25-ны өдрөөс эхлэн мягмар гариг бүр 10:00-12:00 цагийн хооронд зохион байгуулна.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХӨӨРӨХ ТАВЦАН СУРГУУЛЬ